

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
МОНГОЛ ХЭЛ СОЁЛЫН СУРГУУЛЬ
эрдэм шинжилгээний бичиг

XXXVII (392)

2013

(28-32)

**ЭХ ХЭЛНИЙ БОЛОВСРОЛЫГ ОЛГОХОД
ХЭРЭГЛЭГДЭХҮҮНИЙГ АШИГЛАХ АСУУДАЛД**

**Г. Бямбацэрэн,
М. Энхжаргал***

Түлхүүр үг

Боловсролын стандарт, хөтөлбөр, чадвар, захидлын эх

Товч агуулга

Монголын боловсролыг 2006-2015 онд хөгжүүлэх Мастер төлөвлөгөөний тэргүүлэх чиглэлд “Иргэдэд тасралтгүй суралцан, чанартай ажиллаж, амьдрах, сонголт хийх, авьяасаа илрүүлэн хөгжүүлэх эрэлт, хэрэгцээг нь хангахуйц түвшиний боловсролын стандарт, хөтөлбөрийг шинэчлэн, тэдгээрийг хэрэгжүүлэх нийлүүлэлтэд мөрдөх стандарт, бодлого, стратеги, дүрэм, журмыг цогцоор нь шинэчлэн мөрдөх” гэж заасан байдаг.

Үүний дагуу БШУ-ы сайдын 2013 оны 5 дугаар сарын 8 өдрийн А/155 тоот тушаалаар баталсан “Бага, дунд боловсролын чанарын шинэчлэлийн үзэл баримтлал”-д боловсролын хөгжлийн дэлхийн чиг хандлагыг баримжаалсан 12 жилийн сургалтын тогтолцоонд нийцсэн, бага, дунд боловсролын үндэсний стандарт, хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэхээр заасан билээ.

Энэхүү өгүүлэлд шинэчлэн сайжруулж байгаа монгол хэлний хичээлийн хөтөлбөр, стандартад суурилан зохиогдсон сурах бичигт төрөлх хэлийг эзэмшүүлэхдээ хэрэглэгдэхүүнийг хэрхэн ашиглаж байгааг авч үзлээ.

Оршил

Бага, дунд боловсролын стандарт нь тухайн боловсролыг дүүргэх суралцагчийн эзэмшвэл зохих цогц чадамжийг илэрхийлсэн, сургалтын үйл ажиллагааны чанарт тавих наад захын шаардлагыг тодорхойлсон норматив баримт бичиг бол сургалтын хөтөлбөр нь тухайн боловсролоор анги бүрд хүрэх үр дүн буюу нийлүүлэлтийг тодорхойлсон баримт бичиг байдаг.

* Монгол Улсын Боловсролын Их Сургууль, Багшийн сургууль

Монгол улс 1990-ээд оноос хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгмийн харилцаанд шилжсэнээр боловсролын салбар ч өөрийн үйл ажиллагааг энэхүү нийгмийн харилцаанд нийцүүлэн өөрчлөх бодит, шинэ шаардлага, хэрэгцээ тулгарсан юм.

Монгол Улсын Их Хурлын 1995 оны 36 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого”-д бага, дунд боловсролын стандартыг төрөөс тогтоож байх, түүнийг өмчийн бүх хэлбэрийн сургалтын байгууллагад нэгэн адил мөрдүүлэх, хэрэгжилтэд нь хяналт тавих, үнэлэх тогтолцоо бий болгохоор заажээ. Улмаар 1998 онд Гэгээрлийн яамнаас ерөнхий боловсролын агуулгын стандарт, 2004 онд БСШУЯ-аас ерөнхий боловсролын стандарт, 2005 оноос 11 ба 12 жилийн сургуульд судлах хичээл бүрийн агуулгын хүрээ болон үндэсний сургалтын хөтөлбөрүүдийг тус тус боловсруулан сургалтад мөрдөж иржээ.

Монголын боловсролыг 2006-2015 онд хөгжүүлэх Мастер төлөвлөгөөний тэргүүлэх чиглэлд “*Иргэдэд тасралтгүй суралцан, чанартай ажиллаж, амьдрах, сонголт хийх, авьяасаа илрүүлэн хөгжүүлэх эрэлт, хэрэгцээг нь хангахуйц түвшиний боловсролын стандарт, хөтөлбөрийг шинэчлэн, тэдгээрийг хэрэгжүүлэх нийлүүлэлтэд мөрдөх стандарт, бодлого, стратеги, дүрэм, журмыг цогцоор нь шинэчлэн мөрдөх*” гэж заасан байдаг. Үүний дагуу БШУ-ы сайдын 2013 оны 5 дугаар сарын 8 өдрийн А/155 тоот тушаалаар баталсан “Бага, дунд боловсролын чанарын шинэчлэлийн үзэл баримтлал”-д боловсролын хөгжлийн дэлхийн чиг хандлагыг баримжаалсан 12 жилийн сургалтын тогтолцоонд нийцсэн, бага, дунд боловсролын үндэсний стандарт, хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэхээр заасан билээ [БШУ-ы сайдын 2013 оны 5 дугаар сарын 8 өдрийн А/155 тоот тушаал “Бага, дунд боловсролын чанарын шинэчлэлийн үзэл баримтлал”].

Өмнө гарсан (2004) бага, дунд боловсролын монгол хэл, уран зохиолын стандартыг 2013 онд гарсан шинэ стандарттай харьцуулбал, 2004 оноос хэрэгжүүлсэн бага, дунд боловсролын стандарт нь ЮНЕСКО-гоос тодорхойлсон дөрвөн цогц чадамж (К1-К4)-ийг эзэмшүүлэхэд чиглэгдсэний нэгэн адил шинэ стандарт нь мөн адил суралцагчийн цогц чадамжид суурилсан, суурь шийдлээ залгамжлан хадгална.

Харин шинэ стандартад хүүхдийн хөгжил, төлөвшил, монгол хүүхдийн онцлогийг нарийвчлан тодруулсан, сургалтын түвшинд тодорхой буулгасан суралцагчийн цогц чадамжийн загварыг хэрэгжүүлэхээр тусгаснаараа онцлог юм.

Ерөнхийд нь дүгнэн үзвэл, монгол хэлний уламжлалт сургалтад төрөлх хэлний боловсролыг олгохдоо эх, өгүүлбэр, үг буюу хэлний хэрэглэгдэхүүнүүдийг хэлзүйн задлал хийхэд ашиглаж байсан бол, шинэчлэн, сайжруулсан бага боловсролын монгол хэлний сургалтын хөтөлбөр, стандартад хэлний боловсролыг олгоход хэрэглэгдэхүүн нь чадварт суурилсан үйлийн үр дүнд мэдлэг бүтээж байгаа юм. Өөрөөр хэлбэл, хүүхэд унших, бичих, ярих-сонсох үйлийн явцдаа хэлний мэдлэгийг олж авах юм.

Дээрх үйлийг Л.С.Выготский, А.Н.Леонтьев, П.Я.Гальперин нарын хэлийг эзэмших аргыг судалсан онолоор тайлбарлаж болно. Л.С.Выготский хүнд эхлээд санаа төрж, тэр нь онцолбор ялгарч, улмаар хэлний бүтэц буй болдог гэжээ. Харин А.Н.Леонтьев үйл ажиллагаа нь гаднын цочроогч-дотоод үйлдэл болох хувирахаас шалтгаална гэж үзжээ. Л.С.Выготский, А.Н.Леонтьев нарын онолын дагуу П.Я.Гальперин оюуны шатлан төлөвшүүлэх үйлийг дараах байдлаар авч үзжээ. Үүнд:

- I. Үйлийн сэдэл
- II. Үйлийн гүйцэтгэх баримжаа
- III. Бодит зүйлээр үйлдэх

IV. Үйлээ гадаад яриагаар тайлбарлах

V. Өөртөө ярих буюу дотоод яриа

VI. Дотоод яриа нь оюуны үйлдэл болох үе гэсэн дарааллаар танин мэднэ гэжээ.[М.Базаррагчаа, Монгол хэлний өгүүлбэр судлал, Уб, 2006, 416]

Энэ нь мэдлэгийг шууд бэлнээр олгохгүй. Эхлээд сэдэл үүсгэх үйл хийх буюу сэдэлжүүлнэ. Дараа нь тухайн үйлийг хийх баримжаа, төсөөлөлтэй болгоно. Ингээд өөрөө тухайн үйлийг биеэр хийж мэдрэх буюу уншиж, бичиж, ярих-сонсоно. Дотоод яриа нь хүүхэд хэцүү зүйлийг хийж байхдаа амандаа шивнэн ярьдаг. Дээрх дараалал нь шинэчлэн боловсруулсан бага, дунд боловсролын монгол хэл, уран зохиолын стандарт, сургалтын хөтөлбөрийн шинэчлэлийн үзэл баримтлал, монгол хэлний боловсролын зорилготой таарч байгаа юм.

Шинэчлэн сайжруулж байгаа монгол хэлний хичээлийн хөтөлбөр, стандартад суурилан зохиогдож байгаа сурах бичигт төрөлх хэлийг эзэмшүүлэхдээ хэрэглэгдэхүүнийг хэрхэн ашиглаж байгааг авч үзлээ.

Монгол хэлний V ангийн сурах бичигт буй захидлын эхийг хэлний хэрэглэгдэхүүн болгон ашигласан байдлыг судалсан нь

БШУ-ы сайдын 2013 оны 5 дугаар сарын 8 өдрийн А/155 тоот тушаалаар баталсан “Бага, дунд боловсролын чанарын шинэчлэлийн үзэл баримтлал”-д боловсролын хөгжлийн дэлхийн чиг хандлагыг баримжаалсан 12 жилийн сургалтын тогтолцоонд нийцсэн, бага, дунд боловсролын үндэсний стандарт, хөтөлбөр боловсруулсан.

Тухайн хөтөлбөр стандартын дагуу 1-5-р ангийн I улиралд орох монгол хэлний сурах бичгийг бичиж 2013/2014 оны хичээлийн жилд тодорхой сургуулиудад туршина. Уг сурах бичигт төрөл хэлний боловсролыг олгохдоо хэрэглэгдэхүүнийг хэрхэн ашиглаж байгааг 5 ангийн сурах бичгийн жишээн дээр харьцуулан үзлээ.

Нэгдүгээр сурах бичиг:

2012 онд зохиогдож, одоо ЕБС-ийн 5 ангид хэрэглэгдэж байгаа “Монгол хэл V” сурах бичгийн 159 талд С.Дашдэндэвийн “Эхийн захиа” эхийг уншаад дараах асуултад хариулахаар даалгаврын тавил боловсруулжээ. Үүнд:

1. Гаваа хүү юуны учир бараг унтаж чадаагүй вэ?
2. Ээж нь хүүдээ юу гэж захисан бэ?
3. Гаваа хүү ээжийдээ юу гэж хэлсэн бэ?
4. Ээжийн атираа суусан нүүрэн дээгүүр нь нулимс бөмбөрч байв. Яагаад?
5. Гаваа хүүгийн эрхэм зорилго юу вэ? гэжээ.

Сурагчид энэхүү асуулт даалгаварт хариулсны дараа нь дуурайн захиас зохион бичнэ. Дараа нь эхэд буй өгүүлбэрүүдийг хурааж бичих, үйл язгууртай үгийг олж тэмдэглэх гэсэн хэлзүйн дасгал ажил хийж байна. Энэ нь сурах бичгийн 2 нүүр эзэлж байна [Г.Бямбацэрэн нар, Монгол хэлний 5 ангийн сурах бичиг, Уб, 2012, 159].

Хоёрдугаар сурах бичиг:

Харин шинэчлэн сайжруулж буй 5 ангийн монгол хэлний сурах бичигт захидал сэдэв нь сурах бичгийн 8 нүүрийг эзэлж байгаа бөгөөд 8-10 цагийн ээлжит хичээл байхаар төлөвлөжээ. Нэгж хичээлийн агуулгад:

1. Захидал бичиж байсан болон захидлын тухай өмнөх төсөөлөлд нь тулгуурлан мэдлэгээ сэргээж хүнд ярих зүйлээ бэлтгэх юм. Ингэхдээ сурах бичгийн 15-р талын эхний загварыг ажиглаад сонгож ярих боломж олгож байгаа.
2. Захидал явуулах үйл ажиллагаатай танилцуулах буюу дэс дарааллыг эзэмшинэ. Энэ нь гэр бүл, анги хамт олны харилцаанд орох, олох гэж байгаа мэдлэгийнхээ суурьтай танилцах зорилготой юм. Захидлыг зохиохоос гадна бодитой хэрэгжүүлэхээр хийлгэх нь чухал.
3. Сонсох чадвараа хөгжүүлэн тухайн сэдэвтэй холбоотой эхийг анхааралтай сонсоод захидлын эхлэл, гол, төгсгөл хэсгийг ялгаж бичих, захидлын үндсэн санааг тодорхойлно.
4. Өмнө үзсэн хичээлээс олж авсан мэдлэг туршлагадаа тулгуурлан захидлын онцлогийг таних юм.
5. Дурсамж, Өдрийн тэмдэглэл, Захидал гурвын ижил ба ялгаатай талыг харьцуулах
6. Захидлын эхийг уншихын өмнө унших хурдаа нэмэгдүүлэх, хурдан ойлгох чадварын дасгал хийнэ.
7. Захидлын эхийг хурдан уншиж, хурдан ойлгож тусган хүлээж авах, задлан шинжлэх, гадагш нь илэрхийлэх, мэдэхгүй үгийн тайлбар хийх оюуны чадамжаа өсгөнө.
8. Захидлыг бичих арга барилд суралцана.
9. Дуурайн бичих захидалтай танилцах
10. Захидал зохион бичих гэсэн дарааллаар үйл ажиллагаа хийхээр төлөвлөсөн байна[Л.Олзвой нар, Монгол хэлний 5 ангийн сурах бичгийн багшийн ном, Уб, 2013,10 тал].

Энэ дарааллыг үзвэл, хэлзүйн мэдлэгийг шууд олгоогүй, сурагчдын унших, бичих, ярих-сонсох үйлийн явцад захидалгэсэн албан бичгийн нэг төрөл буюу баримтын эхийгбичээд сурч байгаа юм.

Дээрх хоёр сурах бичигт захидал сэдвийг заахдаа хэрэглэгдэхүүн буюу захидлын эхийг хэрхэн ашиглаж байгааг харьцуулбал, нэгдүгээр сурах бичигт бэлэн захидлыг хэлзүйн мэдлэг олгохдоо ашиглаж байгаа бол, хоёрдугаар сурах бичигт сурагчид захидал бичиж сурах алхамчилсан үйлийн явцад хэлний мэдлэгийг эзэмшиж байгаа юм. Энэ нь захидлын тухай мэдлэгээ тэлээд зогсохгүй өөрийгөө илэрхийлэх, боловсруулалт хийх, мэдлэг бүтээх чадварууд, сурах арга барилыг эзэмшээд зогсохгүй, хэлийг хэрэглээ болгон төлөвшүүлж хувь хүний чадварыг хөгжүүлэх зорилготой юм.

НОМЗҮЙ

1. Бага боловсролын монгол хэлний стандарт, БШУ-ы сайдын 2013 оны 5 дугаар сарын 8 өдрийн А/155 тоот тушаал Уб, 2013.
2. Бага боловсролын монгол хэлний сургалтын хөтөлбөр, БШУ-ы сайдын 2013 оны 5 дугаар сарын 8 өдрийн А/155 тоот тушаал, Уб, 2013.
3. Бага, дунд боловсролын стандарт, хөтөлбөрийн шинэчлэлийн үзэл баримтлал, БШУ-ы сайдын 2013 оны 5 дугаар сарын 8 өдрийн А/155 тоот тушаал Уб, 2013.

4. Бага, дунд боловсролын монгол хэл, уран зохиолын боловсролын стандарт, Уб, 2004.
5. Базаррагчаа М, Монгол хэлний өгүүлбэр судлал, Уб., 2006.
6. Бямбацэрэн Г нар, Монгол хэлний 5 ангийн сурах бичиг, Уб, 2012.
7. Бямбацэрэн Г, Хэлний сургалт ба танин мэдэхүй, Уб, 2013.
8. Ерөнхий боловсролын 12 жилийн сургуулийн сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр, зөвлөмж, Уб, 2011.
9. Олзвой Л нар, Монгол хэлний 5 ангийн сурах бичиг, Уб, 2013/И улирал, туршилтын хувилбар/.
10. Олзвой Л нар, Монгол хэлний 5 ангийн сурах бичгийн багшийн ном, Уб, 2013/И улирал, туршилтын хувилбар/.

SUMMARY

At the end I would like to say that learners do not have to use teaching materials, rather than need to create these when teaching own language. As a result, learners will increase and develop and apply all skills such as writing, reading, listening and speaking.

Distinction of the Mongolian culture and tradition, change of the nature, society, ecology requiring this.